



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 23 өдөр

Дугаар №10

Улаанбаатар хот

Г Спорт хамтлагийг шинэчлэн байгуулах  
тухай

Биеийн тамир спортын тухай хуулийн 12 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн <sup>1</sup>13.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн <sup>2</sup>20.10 дахь заалт, Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн <sup>3</sup>6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус Институтийн Биеийн тамир спорт хамтлагийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар байгуулсугай.
2. Албан хаагчдын дунд биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн 02 дугаар сард багтаан батлуулж, уралдаан тэмцээний удирдамж дүрмийг тухай бүр байгууллагын шуурхай хурлаар хэлэлцүүлэн тайлан мэдээг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг Спорт хамтлаг (Э. Эрдэнэмөнх), Хүний нөөц өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн (Ч.Рэнцэнхорлоо) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Биеийн тамир спортын арга хэмжээнд шаардагдах зардлыг тухай бүрд нь төсөв гарган батлуулж, холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хот төлөвлөлт, судалгааны институтийн даргын 2020 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн А/61 дүгээр тушаал хүчингүй болсонд тооцсугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л. Эрдэнэбат)-д даалгасугай.

ДАРГА

Ч.РЭГЗМАА

ТУ31925 9020010718 5369568

3150600052